

ИХЭР МӨРӨН АУДИТ ХХК



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Галт сумын ерөнхий боловсролын сургуулийн 2022 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Аудитын код: ХӨА-2023/153/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас:
www.audit.mn

Мөрөн сум 2023 он

Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газрын дарга,
тэргүүлэх аудитор: А.Эрдэнэбаатар

Утас: 88883317 Цахим хаяг: erdenebaatara@audit.gov.mn

Аудитын менежер: Б.Тэгшдэлгэр

Утас: 99089114 Цахим хаяг: tegshdelgerb@audit.gov.mn

Аудитор: С.Гансүх

Утас: 95908400 Цахим хаяг: gansukhs@audit.gov.mn

Ихэрмөрөн-Аудит ХХК-ийн захирал Б.Мядагмаа

Утас: 99389208 Цахим хаяг: b_myadagmaaa@yahoo.com

Аудитор Б.Нэргүй

Утас: 99010744 Цахим хаяг: nerguib82@gmail.com

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

АГУУЛГА

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ 4

 Асуудлыг онцолсон хэсэг 4

 Аудитын гол асуудал..... 4

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ 6

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА 13

4. АУДИТЫН ТАЙЛАН..... 18

 4.1 Ерөнхий зүйл 18

 4.2 Материаллаг байдал..... 18

 4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт 19

 4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал 19

 4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт 19

 4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт..... 19

 4.5.1 Завсрын аудитын талаар 19

 4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал..... 19

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ 20

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
БШУС	Боловсрол, шинжлэх ухааны сайд
БСШУС	Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайд
БШУГ	Боловсрол, шинжлэх ухааны газар
УИХ	Улсын их хурал
ЗДТГ	Засаг даргын Тамгын газар
ИТХ	Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал



ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

АЗДТГ-ын байр, А корпус 3 давхар,
Мөрөн сум, Хөвсгөл аймаг, 67120
Утас/факс: 7038 3793, Цахим шуудан: khuvsgul@audit.gov.mn
Цахим хуудас: www.audit.mn

АДДБ.ОХ.АД № 01/БТ
танай _____-ны № _____-т

ГАЛТ СУМЫН ЕРӨНХИЙ
БОЛОВСРОЛЫН СУРГУУЛИЙН
ЗАХИРАЛ А.ЦЭРЭНХҮҮ ТАНАА

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Галт сумын ерөнхий боловсролын сургуулийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Галт сумын ерөнхий боловсролын сургуулийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторовын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторовын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Монгол Улсын Засгийн газрын 2022 оны 91 дүгээр тогтоолын 4 дүгээр хавсралтаар батлагдсан "Хувьсах зардлын дундаж нормативаар төсөв хуваарилах, санхүүжүүлэх журам"-ын 8.7 дахь заалтад төсвийн жилийн эцэст зарцуулагдаагүй үлдсэн мөнгөн хөрөнгийг улсын төсөвт татан төвлөрүүлэлгүйгээр дараагийн төсвийн жилд шилжүүлэн зарцуулахаар заасантай холбоотой мөнгөн хөрөнгө данс 23,753.8 мянган төгрөгийн үлдэгдэлтэй гарсан байна.

Аудитын гол асуудал

Тус байгууллага нь 2022 онд боловсролын байгууллагыг үйл ажиллагааны үр дүн, чанар, гүйцэтгэл, сургалтын хөтөлбөрийн бодит өртөгт суурилсан хувьсах зардлаар санхүүжүүлэх, суралцагчийн сурлагын чанарыг хараат бусаар үнэлэх, багшийн ажлын үр дүнг суралцагчийн сурлагын чанартай уялдуулж үнэлэх, үр дүн бүтээмжид суурилсан цалин хөлсний бодлого хэрэгжүүлэхэд чиглэсэн холбогдох эрх зүйн актуудыг шинэчлэн баталж, мөрдүүлсэн асуудлыг аудитын гол асуудал гэж үзлээ.

Бусад асуудлын хэсэг

Сургуулийн захирал Галт сумын Засаг даргатай хийсэн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 8 зорилтын хүрээнд 25 арга хэмжээг төлөвлөж, 85.0 хувьтай дүгнэгдсэн байна.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  А. ЭРДЭНЭБААТАР



2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ**2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан**

/төгрөгөөр/

ДАНС	Үзүүлэлт	ҮЛДЭГДЭЛ	ГҮЙЦЭТГЭЛ
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	220,394,467.77	290,643,426.46
31	МӨНГӨ БА ТҮҮНТЭЙ АДИЛТГАХ ХӨРӨНГӨ	0.00	23,753,859.74
31211	Банкинд байгаа бэлэн мөнгө	0.00	23,753,859.74
35	Төгрөг	0.00	23,753,859.74
351	Төрийн сангийн харилцах	-	23,753,859.74
35450	БАРАА МАТЕРИАЛ	220,394,467.77	266,889,566.72
35460	Түүхий эд материал	-	1,000,000.00
35470	Эм боох материал	-	1,000,000.00
35600	Хангамжийн материал	218,709,467.77	264,014,566.72
2	Бичиг хэргийн материал	12,696,350.00	11,073,350.00
39	Аж ахуйн материал	16,770,638.50	13,285,038.50
392	Түлш шатах тослох материал	10,673,504.22	4,500,001.23
39201	Барилгын засварын материал	680,000.00	31,470,000.00
39202	Хүнсний материал	3,051,304.09	26,413,006.03
39205	Бусад хангамжийн материал	174,837,670.96	177,273,170.96
39206	Мал, амьтад	1,685,000.00	1,875,000.00
39207	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	2,539,257,281.29	2,455,706,041.22
39208	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	2,539,257,281.29	2,455,706,041.22
39213	Биет хөрөнгө	2,457,281,613.25	2,374,951,484.18
39214	Барилга, байгууламж	2,262,156,768.00	2,262,156,768.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	(269,513,121.80)	(333,714,014.24)
39217	Машин, тоног төхөөрөмж	333,145,301.39	415,101,763.39
393	Хуримтлагдсан элэгдэл	(63,616,110.05)	(138,927,334.57)
39301	Тавилга, аж ахуйн эд хогшил	173,211,319.70	180,596,319.70
39302	Хуримтлагдсан элэгдэл	(79,857,265.98)	(97,433,051.01)
39303	Түүх соёлын дурсгалт зүйлс	50,000,000.00	50,000,000.00
3	Бусад үндсэн хөрөнгө	7,193,870.00	7,193,870.00
4136	Хуримтлагдсан элэгдэл	(3,939,771.24)	(5,253,028.32)
41362	Номын фонд	48,500,623.23	35,230,191.23
5	Биет бус хөрөнгө	81,975,668.04	80,754,557.04
51	Програм хангамж	6,105,555.00	6,105,555.00
511	Хасагдуулга	(1,065,686.96)	(2,286,797.96)
51101	Бусад биет бус хөрөнгө	76,935,800.00	76,935,800.00
512	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	2,759,651,749.06	2,746,349,467.68
170	Бусад өглөг	(0.00)	(0.00)
172	Хувь хүмүст төлөх өглөг	(0.00)	(0.00)
214	ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ДҮН	2,759,651,749.06	2,746,349,467.68
215	Засгийн газрын хувь оролцоо	2,759,651,749.06	2,746,349,467.68
216	Засгийн газрын оруулсан капитал /ЗГСан/ орон нутгийн сан	1,154,195,278.41	1,154,195,278.41
217	Өмч: -Төрийн өмч	1,154,195,278.41	1,154,195,278.41
223	Хуримтлагдсан үр дүн	315,892,404.18	302,590,122.80
224	Өмнөх үеийн үр дүн	315,892,404.18	315,892,404.18
225	Тайлант үеийн үр дүн	-	(13,302,281.38)
227	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	1,289,564,066.47	1,289,564,066.47
231	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ДҮН	2,759,651,749.06	2,746,349,467.68

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

/төгрөгөөр/

ДАНС	Үзүүлэлт	ГҮЙЦЭТГЭЛ	ГҮЙЦЭТГЭЛ
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	2,038,207,127.44	2,349,164,014.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	169,659,368.80	40,062,114.00
120	Нийтлэг татварын бус орлого	169,659,368.80	40,062,114.00
120004	Төсөвт байгууллагын өөрийн орлого	169,659,368.80	40,062,114.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	-	9,219,100.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	580,000.00	-
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	169,079,368.80	30,843,014.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	262,696,458.64	2,309,101,900.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	-	1,939,533,200.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	-	1,939,533,200.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	1,605,851,300.00	-
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	9,625,058.64	-
131104	Дээд шатны төсвийн захирагчаас төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захи	9,400,058.64	-
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	225,000.00	-
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	253,071,400.00	369,568,700.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	253,071,400.00	369,568,700.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН (II)	1,909,391,140.90	2,362,466,295.38
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,909,391,140.90	2,362,466,295.38
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,843,316,394.93	2,253,220,531.50
2101	Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил	1,184,091,400.00	1,414,470,254.00
210101	Цалин	835,761,400.00	1,054,295,154.00
210102	Нэмэгдэл цалин	279,730,000.00	302,197,775.00
210104	Урамшуулал	68,600,000.00	57,977,325.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	154,249,859.00	177,252,209.26
210201	Тэтгэврийн даатгалын шимтгэл	108,030,059.00	120,532,301.81
210202	Тэтгэмжийн даатгалын шимтгэл	11,555,000.00	14,179,071.19
210203	ҮОМШ өвчний даатгалын шимтгэл	9,244,000.00	11,344,273.50
210204	Ажилгүйдлийн даатгалын шимтгэл	2,311,000.00	2,830,515.71
210205	Эрүүл мэндийн даатгалын хураамж	23,109,800.00	28,366,047.05
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	248,836,473.99	239,091,991.93
210301	Гэрэл цахилгааны зардал	7,702,450.00	15,591,165.44
210302	Түлш, халаалтын зардал	240,336,473.99	219,000,826.49
210303	Цэвэр, бохир усны зардал	797,550.00	4,500,000.00

Галт сумын ерөнхий боловсролын сургуулийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

2104	Хангамж, бараа материалын зардал	30,820,448.64	42,425,384.00
210401	Бичиг хэргийн материал	1,369,943.64	2,627,900.00
210402	Тээвэр, шатахууны зардал	5,000,000.00	7,101,900.00
210403	Шуудан холбоо интернетийн төлбөр	1,015,400.00	-
210404	Ном, хэвлэлийн зардал	65,600.00	-
210405	Хог хаягдал устгах, цэвэрлэх	1,217,815.00	-
210406	Бага үнэ түргэн элэгдэл зүйлс	10,700,790.00	11,639,600.00
210408	Бараа материал актасны зардал	11,450,900.00	21,055,984.00
2105	Нормативт зардал	86,471,991.94	144,423,940.24
210501	Эм	1,770,400.00	700,000.00
210502	Хоол	82,076,591.94	143,723,940.24
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	2,625,000.00	-
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	16,786,750.00	15,805,000.00
210604	Урсгал засвар	16,786,750.00	15,805,000.00
2107	Томилолт, зочны зардал	1,373,200.00	-
210702	Дотоод томилолтын зардал	1,373,200.00	-
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр хураамж	6,111,400.00	18,405,500.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	5,103,400.00	9,133,000.00
210802	Аудит, баталгаажуулалт зэрэглэл тогтоох зардал	1,008,000.00	-
210806	Мэдээллийн технологийн үйлчилгээний хөлс	-	9,272,500.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	114,574,871.36	201,346,252.07
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	-	25,066,600.00
210902	Хичээл сургалт, үйлдвэрлэлийн дадлагын зардал	8,460,100.00	16,657,382.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	106,114,771.36	159,622,270.07
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	66,074,745.97	109,245,763.88
2132	Бусад урсгал шилжүүлэг	51,427,280.97	104,238,334.82
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	51,017,280.97	104,238,334.82
213209	Нэг удаагийн тэтгэмж шагнал урамшуулал	410,000.00	-
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	14,647,465.00	-
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	14,647,465.00	-
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	-	5,007,429.06
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	-	5,007,429.06
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III=I-II)	128,815,986.54	(13,302,281.38)
5	НИЙТ ҮР ДҮН (VII=III+VI)	128,815,986.54	(13,302,281.38)

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/төгрөгөөр/

ДАНС	Үзүүлэлтүүд	ӨМНӨ ОНЫ ГҮЙЦЭТГЭЛ	ТАЙЛАНТ ОНЫ ГҮЙЦЭТГЭЛ
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	1,868,547,758.64	2,318,321,000.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	-	9,219,100.00
120	Нийтлэг татварын бус орлого	-	9,219,100.00
120004	Төсөвт байгууллагын өөрийн орлого	-	9,219,100.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	-	9,219,100.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,868,547,758.64	2,309,101,900.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	1,605,851,300.00	1,939,533,200.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	1,605,851,300.00	1,939,533,200.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	9,625,058.64	-
131104	Дээд шатны төсвийн захирагчаас төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захи	9,400,058.64	-
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	225,000.00	-
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	253,071,400.00	369,568,700.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	253,071,400.00	369,568,700.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (II)	1,775,550,458.64	2,222,934,140.26
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,775,550,458.64	2,222,934,140.26
210	БАРАА АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,709,780,843.64	2,109,605,196.20
2101	Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил	1,184,194,400.00	1,414,470,254.00
210101	Үндсэн цалин	835,864,400.00	1,054,295,154.00
210102	Нэмэгдэл	279,730,000.00	302,197,775.00
210104	Үр дүнгийн урамшуулал	68,600,000.00	57,977,325.00
2102	Ажил олгочоос нийгтийн даатгалд төлөх шимтгэл	154,249,859.00	177,252,209.26
210201	Тэтгэврийн даатгалын шимтгэл	108,030,059.00	120,532,301.81
210202	Тэтгэмжийн даатгалын шимтгэл	11,555,000.00	14,179,071.19
210203	ҮОМШ өвчний даатгалын шимтгэл	9,244,000.00	11,344,243.50
210204	Ажилгүйдлийн даатгалын шимтгэл	2,311,000.00	2,830,515.71
210205	Эрүүл мэндийн даатгалын хураамж	23,109,800.00	28,366,077.05
2103	Байр ашиглалтай холбоотой тогтмол зардал	241,482,800.00	232,918,488.94
210301	Гэрэл цахилгааны зардал	7,702,450.00	15,591,165.44
210302	Түлш, халаалтын зардал	232,982,800.00	212,827,323.50
210303	Цэвэр, бохир усны зардал	797,550.00	4,500,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	18,908,958.64	-
210401	Бичиг хэрэг	1,658,843.64	-
210402	Тээвэр, шатахуун	5,000,000.00	-
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,015,400.00	-
210404	Ном, хэвлэл	65,600.00	-
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	1,742,815.00	-
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	9,426,300.00	-

Галт сумын ерөнхий боловсролын сургуулийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

2105	Нормативт зардал	82,988,826.00	163,002,462.00
210501	Эм бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	661,600.00	-
210502	Хоол, хүнс	79,015,326.00	163,002,462.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	3,311,900.00	-
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	13,718,600.00	45,000,000.00
210601	Багаж техник хэрэгсэл	2,130,000.00	-
210604	Урсгал засвар	11,588,600.00	45,000,000.00
2107	Томилолт, зочны зардал	1,373,200.00	-
210702	Дотоод албан томилолт	1,373,200.00	
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	6,111,400.00	18,405,500.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил, үйлчилгээний төлбөр хураамж	5,103,400.00	9,133,000.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	1,008,000.00	-
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	-	9,272,500.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	6,752,800.00	58,556,282.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	-	39,690,300.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлаг хийх	6,752,800.00	18,865,982.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	65,769,615.00	113,328,944.06
2132	Бусад урсгал шилжүүлэг	51,122,150.00	108,321,515.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж урамшуулал	51,122,150.00	108,321,515.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	14,647,465.00	-
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	14,647,465.00	-
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	-	5,007,429.06
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	-	5,007,429.06
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	92,997,300.00	95,386,859.74
	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	-	-
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)	92,997,300.00	71,633,000.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	92,997,300.00	71,633,000.00
2200	Дотоод эх үүсвэрээр	92,997,300.00	71,633,000.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	92,997,300.00	71,633,000.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	(92,997,300.00)	(71,633,000.00)
	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	-	-
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	-	23,753,859.74
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	0.00	0.00
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	0.00	23,753,859.74

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C01	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,154,195,278.41	1,290,149,926.47	186,490,557.64	2,630,835,762.52
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	585,860.00	585,860.00
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	1,154,195,278.41	1,290,149,926.47	187,076,417.64	2,631,421,622.52
C07	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	128,815,986.54	128,815,986.54
C08	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,154,195,278.41	1,289,564,066.47	315,892,404.18	2,759,651,749.06
D01	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,154,195,278.41	1,289,564,066.47	315,892,404.18	2,759,651,749.06
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	1,154,195,278.41	1,289,564,066.47	315,892,404.18	2,759,651,749.06
D08	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	-13,302,281.38	-13,302,281.38
D09	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,154,195,278.41	1,289,564,066.47	302,590,122.80	2,746,349,467.68

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан /Улсын төсөв/

/төгрөгөөр/

Данс	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Дүн	Хувь
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	0.00	(0.00)	-
2	I. НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,948,736,200.00	1,924,998,440.26	23,737,759.74	98.78
21	УРСГАЛ ЗАРДЛЫН ДҮН	1,948,736,200.00	1,924,998,440.26	23,737,759.74	98.78
210	Бараа, үйлчилгээний зардал	1,840,414,000.00	1,816,676,925.26	23,737,074.74	98.71
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,345,611,800.00	1,337,451,781.00	8,160,019.00	99.39
210101	Үндсэн цалин	1,025,028,000.00	985,680,717.00	39,347,283.00	96.16
210102	Нэмэгдэл	282,083,800.00	298,559,135.00	(16,475,335.00)	105.84
210104	Урамшуулал	38,500,000.00	53,211,929.00	(14,711,929.00)	138.21
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	168,201,400.00	167,627,900.26	573,499.74	99.66
210201	Тэтгэврийн даатгал	114,377,000.00	113,947,992.81	429,007.19	99.62
210202	Тэтгэмжийн даатгал	13,456,100.00	13,419,071.19	37,028.81	99.72
210203	ҮОМШӨ ний даатгал	10,764,900.00	10,736,243.50	28,656.50	99.73
210204	Ажилгүйдлийн даатгал	2,691,200.00	2,678,515.71	12,684.29	99.53
210205	Эрүүл мэндийн даатгал	26,912,200.00	26,846,077.05	66,122.95	99.75
2105	Нормативт зардал	174,404,200.00	163,002,462.00	11,401,738.00	93.46

Галт сумын ерөнхий боловсролын сургуулийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

210502	Хоол, хүнс	174,404,200.00	163,002,462.00	11,401,738.00	93.46
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр	21,710,300.00	18,405,500.00	3,304,800.00	84.78
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	9,133,000.00	9,133,000.00	-	100.00
210806	Мэдээллийн технологийн зардал	12,577,300.00	9,272,500.00	3,304,800.00	73.72
2201	Бараа үйлчилгээний бусад зардал	130,486,300.00	130,189,282.00	297,018.00	99.77
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	111,620,300.00	111,323,300.00	297,000.00	99.73
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	18,866,000.00	18,865,982.00	18.00	100.00
	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	108,322,200.00	108,321,515.00	685.00	100.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	108,322,200.00	108,321,515.00	685.00	100.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, дэмжлэг	108,322,200.00	108,321,515.00	685.00	100.00
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	1,948,736,200.00	1,948,752,300.00	(16,100.00)	100.00
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	1,939,533,200.00	1,939,533,200.00	-	100.00
131001	Улсын төсвөөс санхүүжих	1,939,533,200.00	1,939,533,200.00	-	100.00
120004	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	9,203,000.00	9,219,100.00	(16,100.00)	100.17
1200041	Үндсан үйл ажиллагааны орлогоос санхүүжих	9,203,000.00	9,219,100.00	(16,100.00)	100.17
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	0.00	(0.00)	-
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	23,753,859.74	(23,753,859.74)	-
6	ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ	-	-	-	-
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	-	-	-	-
62	АЖИЛЛАГСДЫН ТОО	97.00	97.00	-	100.00
620001	Удирдах ажилтан	1.00	1.00	-	100.00
620002	Гүйцэтгэх ажилтан	61.00	61.00	-	100.00
620003	Үйлчлэх ажилтан	35.00	35.00	-	100.00

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан /Орон нутгийн төсөв/

Данс	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	/төгрөгөөр/	
				Дүн	Хувь
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	-	-	-
2	I. НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	369,568,700.00	364,561,270.94	5,007,429.06	98.65
21	УРСГАЛ ЗАРДЛЫН ДҮН	369,568,700.00	364,561,270.94	5,007,429.06	98.65
210	Бараа, үйлчилгээний зардал	369,568,700.00	364,561,270.94	5,007,429.06	98.65
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	79,611,200.00	77,018,473.00	2,592,727.00	96.74
210101	Үндсэн цалин	79,611,200.00	68,614,437.00	10,996,763.00	86.19
210102	Нэмэгдэл	-	3,638,640.00	(3,638,640.00)	-
210104	Урамшуулал	-	4,765,396.00	(4,765,396.00)	-
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	9,951,300.00	9,624,309.00	326,991.00	96.71
210201	Тэтгэврийн даатгал	6,766,900.00	6,584,309.00	182,591.00	97.30
210202	Тэтгэмжийн даатгал	796,100.00	760,000.00	36,100.00	95.47
210203	ҮОМШӨ ний даатгал	636,900.00	608,000.00	28,900.00	95.46
210204	Ажилгүйдлийн даатгал	159,200.00	152,000.00	7,200.00	95.48
210205	Эрүүл мэндийн даатгал	1,592,200.00	1,520,000.00	72,200.00	95.47
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	235,006,200.00	232,918,488.94	2,087,711.06	99.11
210301	Гэрэл цахилгаан	17,000,000.00	15,591,165.44	1,408,834.56	91.71
210302	Түлш, халаалт	213,506,200.00	212,827,323.50	678,876.50	99.68
210303	Цэвэр, бохир ус	4,500,000.00	4,500,000.00	-	100.00
2106	Эд хогшил худалдан авах	45,000,000.00	45,000,000.00	-	100.00
210604	Урсгал засвар	45,000,000.00	45,000,000.00	-	100.00
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	369,568,700.00	364,561,270.94	5,007,429.06	98.65
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	369,568,700.00	364,561,270.94	5,007,429.06	98.65
132001	Орон нутгийн төсвөөс	369,568,700.00	364,561,270.94	5,007,429.06	98.65
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	-	-	-
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	-	-	-

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

1.6.1 Байгууллагын үйл ажиллагааны чиглэл, зорилго, зорилтын талаар: Галт сумын ерөнхий боловсролын сургууль нь бага болон суурь, дунд боловсрол олгох сургалтын үйл ажиллагаа явуулдаг, Боловсрол Шинжлэх Ухааны Яамны харьяа байгууллага юм.

Сургуулийн үйл ажиллагааны үндсэн зорилт нь суралцагчдад боловсролын стандартаар тогтоосон бага, суурь, бүрэн дунд боловсрол эзэмшүүлэх, тэдний хөгжих, төлөвших үйл явцыг шинжлэх ухааны үндэстэй удирдах, зохион байгуулах, эцэг, эх, асран хамгаалагчтай хамтран ажиллах, тэдэнд мэргэжлийн зөвлөгөө, туслалцаа дэмжлэг үзүүлэхэд оршино.

Тус сургууль нь 2022 онд “Хамтын ажиллагаанд тулгуурлан суралцагчдын сурах үйл явцыг идэвхжүүлж багшийн тасралтгүй хөгжлийг дэмжин сургалтын хөтөлбөрийг үр дүнтэй хэрэгжүүлнэ” гэсэн зорилго тавьж ажилласан ба энэхүү зорилгын хүрээнд багш, сургууль, суралцагч, эцэг эхийн хөгжилд чиглэсэн зорилтуудыг дэвшүүлэн ажилласан байна.

Сургуулийн захирал Галт сумын Засаг даргатай хийсэн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 8 зорилтын хүрээнд 25 арга хэмжээг төлөвлөж, 85.0 хувьтай дүгнэгдсэн байна.

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Байгууллагын үйл ажиллагаа явуулж буй хууль эрх зүйн орчны талаар: Засгийн газраас 2022 онд боловсролын салбарт шинэчлэл хийж, түүнийг дэмжсэн төсвийг батлан хэрэгжүүлэхийг зорьсон байна. Боловсролын тухай хууль, Сургуулийн өмнөх боловсролын тухай хуулийг 2021 онд өөрчлөн найруулснаар гүйцэтгэл, үр дүнд суурилсан санхүүжилтийн тогтолцоог бий болгож, “хувьсах зардал”-ыг улсын төсвөөс санхүүжүүлэх болсон байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

1. Хөдөлмөрийн тухай хуулийн шинэчилсэн найруулга 2022 оны 1 дүгээр сарын 1-нээс хэрэгжиж эхэлсэн.
2. Төрийн бүх шатны байгууллага, нийтийн алба, тэдгээрийн үйл ажиллагаанд санхүүгийн сахилга бат мөрдүүлж, ил тод байдлыг хангах, үр ашгийг нэмэгдүүлэх, үрэлгэн байдлыг хязгаарлах хяналт тавихад чиглэсэн “Төрийн хэмнэлтийн тухай” хууль хэрэгжиж эхэлсэн.
3. Төрийн үйлчилгээний албан тушаал эрхэлдэг төрийн албан хаагчийн цалингийн доод хэмжээг Засгийн газрын 2022 оны 107 дугаар тогтоолоор тогтоосон ба 2022 оны 192 дугаар тогтоолоор эрүүл мэндийн салбараас бусад төрийн үйлчилгээний байгууллага болон төрийн байгууллагын хэвийн үйл ажиллагааг хангахад туслах албан тушаалын цалингийн доод хэмжээг өөрчлөн тогтоосон байна.
4. Боловсролын салбарт хийж байгаа шинэчлэл, үйл ажиллагаа, төсөв санхүүг дэмжсэн шийдвэрийг Засгийн газар, салбарын яамнаас гаргаж мөрдүүлсэн байна. Тухайлбал:
 - Засгийн газрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн 403 дугаар тогтоолоор Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Боловсролын ерөнхий газрыг байгуулсан ба 2022 оны 131 дүгээр тогтоолоор Боловсролын ерөнхий газрын даргыг Сургуулийн өмнөх болон бага, дунд боловсролын, мэргэжлийн боловсролын, техникийн боловсролын сургалтын байгууллагын төсвийн төвлөрүүлэн захирагчаар баталсан байна.
 - Засгийн газрын 2022 оны 91 дүгээр тогтоолоор “Сургуулийн өмнөх боловсрол эзэмшүүлэхэд нэг суралцагчдад хувьсах зардлын дундаж норматив, түүний бүрэлдэхүүн”, “Төрийн болон орон нутгийн өмчит цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуулийн нэг суралцагчид ногдох хувьсах зардлын байршил, хэв шинж, хүүхдийн тооноос хамаарсан өсөн нэмэгдэх итгэлцүүр”, “Хувьсах зардлын дундаж нормативаар төсөв хуваарилах, санхүүжүүлэх аргачлал” баталсан байна.
 - БШУС-ын 2022 оны А/122 дугаар тушаалаар Засгийн газрын 2022 оны 91 дүгээр тогтоолыг үндэслэн төрийн болон орон нутгийн өмчит сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын сургуулийн үйлчилгээний албан тушаал эрхэлдэг төрийн зарим албан хаагчийн цалингийн хэмжээг тогтоосон.
 - БШУС-ын 2022 оны А/170 дүгээр тушаалаар “төрийн болон орон нутгийн өмчийн ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэгийн хичээл сургалтын үйл ажиллагааны зардлыг төлөвлөх хуваарилах заавар”-ыг 1 дүгээр, “багшийн тасралтгүй хөгжлийг дэмжих, үйл ажиллагааны санхүүжилт, түүнийг зарцуулах заавар”-ыг 2 дугаар, “цахим хэрэглээний зардлыг төлөвлөх, хуваарилах заавар”-ыг 3 дугаар, “тоног

төхөөрөмжийн нөхөн хангалтын зардлыг төлөвлөх хуваарилах, санхүүжүүлэх зааврыг 4 дүгээр хавсралтаар тус тус баталсан байна.

- БШУС-ын 2022 оны А/259 дүгээр тушаалаар “Цэцэрлэг, ерөнхий боловсролын багшийг эрүүл мэндийн нэмэлт үзлэг, оношилгоонд хамруулах заавар”-ыг баталсан байна.
- БШУС-ын 2022 оны А/430 дугаар тушаалаар багшийн ажлыг үнэлэх журмыг шинэчлэн баталсан.
- БШУС-ын 2022 оны А/452 дугаар тушаал “Хувьсах зардлын тоног төхөөрөмжийн нөхөн хангалтын тухай”
- БШУС-ын 2022 оны А/465 дугаар тушаал “ Ерөнхий боловсролын сургуульд кабинет, лаборатори, цахим сургалтын танхим байгуулах, ашиглах нийтлэг журам”
- БШУС-ын 2022 оны А/500 дугаар тушаалаар төрийн болон орон нутгийн өмчийн цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуулийн үйл ажиллагааны гүйцэтгэлийн чанар, үр дүнг үнэлж, үр дүнгийн нэмэлт урамшууллын зардлыг санхүүжүүлэхэд баримтлах чиглэлийг баталсан.

Байгууллагын дотоод хяналтын талаар: Засгийн газрын 2011 оны 311 дүгээр тогтоолоор баталсан Аж ахуйн нэгж, байгууллагын үйл ажиллагаанд дотоод хяналт шалгалтыг зохион байгуулах нийтлэг журам”-ийн дагуу сургуулийн захирлын 2022 оны Б/02 тоот тушаалаар дотоод хяналт хэрэгжүүлэх ажлын хэсгийг 5 хүний бүрэлдэхүүнтэй баталсан байна.

Дотоод хяналтын ажлын хэсэг нь 2022 онд хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөг 1 дүгээр сард батлуулан, тухайн онд нийт 12 удаа дотоод хяналтыг хэрэгжүүлж зөвлөмж өгч ажилласан байна.

Түүнчлэн 2022 онд сургуулийн захирлын тушаалаар шинээр гарсан дүрэм, журмуудын хэрэгжилтийг хангах, байгууллагын үйл ажиллагааг сайжруулах, төсөв санхүүг зарцуулах, түүнд хяналт тавих, худалдан авах ажиллагааг зохион байгуулах, шинээр гарсан дүрэм, журмын хэрэгжилтийг хангах чиг үүрэг бүхий зөвлөл, ажлын хэсэг, багуудыг томилж ажиллуулсан байна.

Тус сургууль нь 2022 онд Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2022 оны 64 дүгээр тогтоолоор төрийн болон орон нутгийн өмчийн эд хөрөнгийн улсын үзлэг тооллого, захирлын тушаалаар тооллогын комисс томилон нд хөрөнгийн тооллого зохион байгуулж үр дүнг тооцон ажилласан байна.

Эдгээр зохион байгуулалтын арга хэмжээний хүрээнд байгууллагын санхүүгийн үйл ажиллагааны дотоод хяналтын 1 ба 2 дугаар үе шатны тогтолцоо бий болсон байна гэж үзлээ.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна гэж үзлээ.

Тайлант онд БШУЯ, БШУГ, аймгийн НДХ, Татварын хэлтэс, Санхүүгийн хяналт, дотоод аудитын албанаас тус сургуульд хяналт шалгалт хийгээгүй байна.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Галт сумын ерөнхий боловсролын сургуулийн 2022 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэж, Төсвийн тухай хуулийн 54.4, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 8 дугаар зүйлд заасан иж бүрдийн дагуу бэлтгэж толилуулсан байна гэж үзлээ.

Харин төсвийн гүйцэтгэлийн тайланг мөнгөн сууриар бэлтгэж, Төсвийн тухай хуулийн 54 дүгээр зүйлийн 54.5 дахь заалтад заасан заалтын дагуу иж бүрэн ирүүлсэн.

Байгууллагын мөрдөж буй нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийн талаар: Санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаандаа БСШУС-ын 2017 оны А/40 дүгээр тушаалаар баталсан “Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг”-ийг үйл ажиллагаандаа ашиглаж, санхүү, төсөв нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаандаа УСНББОУС, Засгийн газар, Сангийн яамнаас гаргасан журам, зааврыг мөрдөж ажилласан байна. Тус Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичигт тусгагдсан зарим журам заавар шинэчлэгдсэнтэй холбоотойгоор нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг өөрийн байгууллагын үйл ажиллагаандаа тохируулан боловсруулах шаардлага тулгарч байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Галт сумын ерөнхий боловсролын сургуулийн 2022 оны жилийн эцсийн санхүүгийн тайланг Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ын дагуу бэлтгэсэн байна. Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 13,302.3 мянган төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Мөнгөн хөрөнгө	-	23,753.9	23,753.9
Авлага	-	-	-
Урьдчилгаа	-	-	-
Бараа материал	220,394.5	266,889.6	46,495.1
Үндсэн хөрөнгө	2,539,257.3	2,455,706.0	(83,551.2)
Нийт хөрөнгө	2,759,651.7	2,746,349.5	(13,302.3)
Өр төлбөр	-	-	-
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	2,759,651.7	2,746,349.5	(13,302.3)
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн	2,759,651.7	2,746,349.5	(13,302.3)

Дээрх хүснэгтээс харахад мөнгөн хөрөнгө, авлага, урьдчилгаа, бараа материал, эздийн өмчийн данс өмнөх оноос нэмэгдэж, үндсэн хөрөнгө данс буурсан үзүүлэлттэй байна. Үүнд:

1. Тайлант онд мөнгөн хөрөнгө дансны үлдэгдэл 23,753.8 мянган төгрөгөөр нэмэгдсэн нь улсын төсвөөс хүлээн авсан санхүүжилтийн зарцуулагдаагүй үлдэгдлийг буцаан төвлөрүүлээгүй нь гол нөлөө үзүүлсэн байна.
